

БАТЛАВ:
ДАРГА



Ц. УРАНЧИМЭГ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
“ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК
ЗАХИРАЛ



Ц.ДАВААЦЭРЭН

“ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК НИЙ ТӨВ АЙМАГ, СЭРГЭЛЭН СУМ, 1-Р БАГ
БАЯН УУЛЫН БАРУУН ТАЛД НУТАГТ ОРШИХ “ЗҮҮН БҮСИЙН
САЙЖРУУЛСАН ШАХМАЛ ТҮЛШНИЙ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2023 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6311709



ХЯНАСАН:



ПҮРЭВ. ШИНЭЦЭЦЭГ

БОЛОВСРУУЛСАН:
“ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК
БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЭРГЭЖИЛТЭН



Б. БИЛГҮҮТЭЙ

2023 ОН



“Таван толгой түлш” ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “600000 тн/жил хүчин чадалтай сайжруулсан шахмал түлшний үйлдвэр” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

ГАРЧИГ

БҮЛЭГ 1.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
1.1 Төслийн нэр	2
1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	2
1.3 Төслийн хүчин чадал	3
1.4 Үйлдвэрийн түүхий эд, технологийн схем.....	3
1.5 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж	4
1.6 Үйлдвэрийн дэд бүтэц	5
БҮЛЭГ 2.ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	8
2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл.....	8
2.2 Уур амьсгал.....	9
2.3 Хөрсөн бүрхэвч.....	10
2.4 Ургамлан нөмрөг	11
2.5 Төсөл хэрэгжих орон нутгийн нийгэм эдийн засгийн байдал	11
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	13
3.1 Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	13
3.2 Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл	13
3.3 Ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл	13
3.4 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл	14
3.5 Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл үргэлжлэх хугацаа,эрчим	14
БҮЛЭГ 4. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	18
4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах менежментийн төлөвлөгөө.....	19
4.2 Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	21
4.3 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	21
4.4 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	22
4.5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	24
4.6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	25
4.7 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	26
4.8 Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	27



“Таван толгой түлш” ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “600000 тн/жил хүчин чадалтай сайжруулсан шахмал түлшний үйлдвэр” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

БҮЛЭГ 1.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн нэр

“600000 тн/жил хүчин чадалтай сайжруулсан шахмал түлшний үйлдвэр”

1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч: “Тавантолгой түлш” ХХК

Улсын бүртгэлийн 9011743088

дугаар:

Регистрийн дугаар: 6311709

Утас: 75553399

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж, “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн Б байр, 121 тоот



Зураг 1. “Тавантолгой түлш” ХХК-ийн 600,000 тн хүчин чадалтай үйлдвэрийн байр



“Таван толгой түлш” ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “600000 тн/жил хүчин чадалтай сайжруулсан шахмал түлшний үйлдвэр” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

1.3 Төслийн хүчин чадал

Хүчин чадал: Тус үйлдвэр нь өдөрт 2200-2300 тн, жилд 600.000 мян.тн шахмал түлш үйлдвэрлэх хүчин чадалтай байна.

1.4 Үйлдвэрийн түүхий эд, технологийн схем

Түүхий эд: “Таван толгой түлш” ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр нь “Энержи Ресурс” ХХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэрээс гардаг завсрын бүтээгдэхүүн болох угааж баяжуулсан эрчим хүчний нүүрс буюу миддлингийг хүлээн авч боловсруулдаг.

Тус баяжуулах үйлдвэрээс гарч буй завсрын бүтээгдэхүүн, нунтаг хаягдал нь 5000-5400 ккал/кг илчлэг бүхий тодорхой технологиудаар боловсруулан эрчим хүчний эх үүсвэр гарган авах боломжтой түүхий эд юм.

Ухаа худгийн баяжуулах үйлдвэрийн баяжмал ба завсрын бүтээгдэхүүн буюу эрчим хүчний нүүрсний чийглэгийн хэмжээ 6%-иас ихгүй, үнслэг 28%-иас ихгүй, хүхрийн агууламж 1.3%-иас ихгүй, дэгдэмхий бодисын агуулга 26%-иас ихгүй илчлэг 5500 ккал/кг-аас багагүй техникийн үзүүлэлттэй байгаа нь "Баяжуулсан нүүрс. Техникийн шаардлага MNS 6226 : 2011" стандартад нийцэж байна.

Технологийн схем: Нунтаг нүүрсийг бүхэллэг хэлбэрт хувирган шахмал түлш гарган авах процессыг нүүрсийг бүхэллэгжүүлэх (шахмал-брикет) гэж нэрлэнэ. Бүхэллэгжүүлэх процессыг ердийн болон өндөр температурт барьцалдуулагчтай болон барьцалдуулагчгүйгээр явуулж болно. Барьцалдуулагч ашиглаагүй тохиолдолд нүүрсийг бүхэллэг хэлбэрт шилжүүлэхэд өндөр даралтаар шахаж хийдэг.



Схем №. 1 Үйлдвэрийн технологийн процесс



Нүүрсийг бүхэллэгжүүлэх процесс нь дараах үндсэн шат дамжлагуудаас бүрдэнэ.

Үүнд:

- Нүүрсний чийгийн агуулга нь шахмалын бат бөх чанарт ихээхэн нөлөөтэй тул нүүрсийг урьдчилан хатааж, чийгийн тодорхой агуулгатай болгох шаардлага гардаг. Хатаах температур нь 100°C-200°C хооронд байх бөгөөд чийгийн агуулгыг 15-18% болгох шаардлагатай.
- Нүүрсийг буталж нүүрсний ширхэглэлийн хэмжээ жигд, жижиг байлгах нь шахмалын бат бөх чанарыг дээшлүүлдэг.
- Шахмалыг ачих, буулгах, хадгалах, тээвэрлэхэд бутарч, нунтаграхгүй шинж чанартай болгоход барьцалдуулагч гол үүрэгтэй. Барьцалдуулагчийг шахмал түлшний нийт жингийн 2-10%-иар тооцон хольж өгдөг. Нүүрс ба барьцалдуулагчийн хольцыг төрөл бүрийн хэлбэржүүлэх, даралтат шахуургуудаар оруулж хэвлэнэ.
- Шахмал нь төрөл бүхийн хэлбэртэй байж болох боловч хамгийн өргөн дэлгэрсэн хэлбэр нь дэр, өндгөн хэлбэртэй байдаг.
- Шахуурга нь хольцын нягтыг 3-5 дахин ихэсгэдэг.
- Барьцалдуулагчгүйгээр бүхэллэгжүүлэх процессд даралт, температур болон шахах хугацаа нь ихээхэн чухал нөлөөтэй.
- Хэвлэгдэн гарсан утаагүй шахмал түлшийг битүү дамжуулгат төхөөрөмж дотор халуунаар үлээлгэх байдлаар шахмалыг хатааж хөргөнө.

1.5 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж

Шахмал түлшний үйлдвэрийн тоног төхөөрөмж нь эргэлтэт хүрдэн хатаагч, түүхий эдийн тэжээлийн туузан конвейр, хос голтой холигч төхөөрөмж, хэлбэржүүлэн шахам төхөөрөмж, туузан хатаагч төхөөрөмж, босоо хатаагч бункер, бэлэн бүтээгдэхүүний туузан конвейр, сайжруулсан шахмал түлш савлагч төхөөрөмжөөс бүрдэнэ.



“Таван толгой түлш” ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “600000 тн/жил хүчин чадалтай сайжруулсан шахмал түлшний үйлдвэр” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө



Зураг №. 1 Үйлдвэрийн тоног төхөөрөмж

1.6 Үйлдвэрийн дэд бүтэц

Барилга байгууламж: Тус үйлдвэр дараах цех, хэсгүүдтэйгээр байгуулагдсан байна. Үүнд:

- Нүүрсний хаягдлыг хүлээн авч хадгалах агуулах;
- Хольц бэлтгэл, шахаж хэлбэржүүлэх цех;
- Бүтээгдэхүүний хатаалт, савлагааны цех зэрэг болно.

Усан хангамж: Тус үйлдвэр нь өөрийн эзэмшлийн өрөмдөл гүний худгаас хангана.

Үйлдвэрийн ашиглалтын хүрээнд дараах усны хэрэглэгч байна. Үүнд:

- Ажилчдын унд ахуйн хэрэглээ
- Технологийн усны хэрэглээ
- Ногоон байгууламж усалгаа

Ахуйн зориулалтаар: Усыг хоол унданд, эрүүл ахуйн шаардлагын дагуу ажилчдын халуун усны газарт, хүйтний улиралд ажлын байр болон орон сууцны халаалтын зориулалтаар усыг хэрэглэнэ.

Ногоон байгууламж услах зориулалтаар: Эвдрэлд өртсөн талбайг нөхөн сэргээж зүлэгжүүлсэн талбайг болон мод, бут ургамлыг услах зориулалтаар хэрэглэнэ.

Үйлдвэрийн технологийн зориулалтаар: Сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх зэрэгт тус тус хэрэглэнэ.



“Таван толгой түлш” ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “600000 тн/жил хүчин чадалтай сайжруулсан шахмал түлшний үйлдвэр” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Ногоон байгууламж усалгааны тооцоо: Ногоон байгууламж усалгааны хэрэглээг БОАЖЯ-ны сайдын 2015 оны 07-р сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 13 дугаар хавсралтад зааснаар цэцэрлэг зүлэг ногоо услах норм 0.004 м^3 байна.

Хүснэгт №. 1 Бут сөөг усалгаанд шаардлагатай усны тооцоо

Зориулалт	Нөхөн сэргээлтийн усны тооцоо				
	Норм (л/м ³)	Талбай (м ²)	Хоногт услах хэмжээ м ³ /хон	Жилд услах хоног	Нийт жилд услах хэмжээ, м ³
Бут, сөөг услах	0.004	4000	16	30	480

Унд ахуйн усны тооцоо: Зүүн үйлдвэрт нийт 524 хүн ажиллах ба өдөрт 4 ээлжээр, 12 цагаар тасралтгүй үйл ажиллагаа явагдах ба жилд 215 хоног ажиллана. Үйлдвэрийн унд ахуйн усны хэрэглээг 2015 оны 07 сарын 30-ны өдрийн Байгаль орчны сайдын тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах ус хэрэглээний норм”-ыг үндэслэн нэг хүний хоногийн унд, ахуйн хэрэгцээний ус 80 л/хоног байхаар тооцсон.

Хүснэгт №. 2 Унд ахуйн хэрэгцээний усны тооцоо

Ашиглалтын жил	Хоногийн усны хэрэглээ, норм м ³	Ажилчидын тоо	Жилд ажиллах хоног	Хоногийн усны хэрэглээ, м ³	Жилийн усны хэрэглээ, м ³
1	0.08	524	215	41.92	9,012.8

Үйлдвэрийн технологийн усны хэмжээ: 1 тн шахмал түлш үйлдвэрлэхэд 50 л ус хэрэглэх бөгөөд жилд 23 мян.м³ усыг технологийн зориулалтаар ашиглана.

Хүснэгт №. 3 Үйлдвэрийн технологийн усны хэрэглээ

№	Үзүүлэлт	Усны хэрэглээ
1	Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн цэвэр усны хоногийн хэрэглээ, м ³ /хон	110 м ³ /хон
2	Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн жилийн хэрэглээ, м ³ /жил	23650 м ³ /жил



“Таван толгой түлш” ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “600000 тн/жил хүчин чадалтай сайжруулсан шахмал түлшний үйлдвэр” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Нийт усны тооцоо

Хүснэгт №. 4 Нийт усны тооцоо

№	Ус ашиглалтын хэлбэр	Усны эх үүсвэр	Ашиглах усны хэмжээ	
			Хоног	1 жил
1	Ажилчдын унд ахуйн усны хэрэглээ	Өрөмдөл гүний худгаас	41.92 м ³ /хон	9012.8 м ³ / жил
2	Технологийн ус		110 м ³ /хон	23650 м ³ / жил
3	Ногоон байгууламжийн усалгаа		16 м ³ /хон	480 м ³ /жил
Нийт			167.92 м ³ /хон	33,142.8 м ³ /жил

Сайжруулсан шахмал түлшний үйлдвэр нь жилд 33,142.8 м³ ус ашиглах бөгөөд өөрийн эзэмшлийн гүний худгаас хангана.



“Таван толгой түлш” ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “600000 тн/жил хүчин чадалтай сайжруулсан шахмал түлшний үйлдвэр” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө


БҮЛЭГ 2.ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл

“Тавантолгой түлш” ХХК-ийн “600000 тн/жил хүчин чадалтай сайжруулсан шахмал түлшний үйлдвэр төсөл” нь Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутагт, Баян уулын баруун талд 4-р зөрлөг нэртэй газар байрладаг. Улаанбаатар хотын төвөөс зүүн урд зүгт 30 км-т, Зуунмод хотоос зүүн зүгт 20 км зайд байрлаж байна. Тус үйлдвэр нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 11-р хороо болон Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутагт байрлах бөгөөд нийт талбайн хэмжээ нь 89.73 га байна.

Төв аймгийн Сэргэлэн сумын засаг даргын захирамжийн 2020 оны 03 сарын 26 өдрийн А/154 тоот шийдвэрийг үндэслэн Төв аймгийн Сэргэлэн сум Баян уулын баруун талд байрлах, нэгж талбарын 4109054160 дугаар бүхий 69,9585 га газрыг Үйлдвэрийн барилга, байгууламж, бусад газрын зориулалтаар эзэмшдэг.

Нийслэлийн Засаг даргын захирамжийн 2021 оны 03 сарын 10 өдрийн А/152 шийдвэрийг үндэслэн Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 11-р хороонд нэгж талбарын 1333109273 дугаар бүхий 19,78 га талбайг үйлдвэрлэлийн зориулалтаар эзэмшдэг.




Зураг №. 2 Төслийн талбайн байршил



“Таван толгой түлш” ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “600000 тн/жил хүчин чадалтай сайжруулсан шахмал түлшний үйлдвэр” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Монгол орны физик газарзүйн мужлалаар Хэнтийн уулархаг мужийн баруун урд үзүүрт Туул голын хөндийн 2.5-4 км хүртэл өргөссөн татам болон дэнж, Их Хэнтэйн нурууны баруун өмнөд салбар уулс, түүний дэд мужийн ойт хээрийн бүсэд далайн түвшнээс дээш 1950-2265 м үнэмлэхүй өндөртэй Горхи, Тэрэлж, Богд хан, зэрэг биеэ даасан өндөрлөг уулс, тэдгээрийн салбар уулсаар Туул голын 1250-1345 м үнэмлэхүй өндөр бүхий тэвш маягийн хөндийн 2.5-4.0 км хүртэл өргөссөн татам, дээрх уулсын энгэр, бэл, хормой, дэнжид тархан оршдог. Газарзүйн бүсчлэлээр ойт хээрийн бүсэд багтана.



Зураг №. 3 Төслийн талбайн физик газарзүй

2.2 Уур амьсгал

Төв аймгийн Сэргэлэн сумын уур амьсгалын нөхцөл нь Монгол орны нутаг дэвсгэрийн нэгэн адил эх газрын эрс тэс шинжтэй, өвөл нь хүйтэн, удаан үргэлжилдэг, зун нь халуун богино, хавар намар нь улирлын шилжилтээс хамааран салхи, шуурга ихтэй байдаг онцлогтой.

Зуны улиралд эх газрын дулаан хуурай агаар зонхилдог. Иймээс орох хур тунадас ихэнхдээ аадар шинжтэй байдаг. Намар хур тунадас багасаж, цочир хүйтрэлт




“Таван толгой түлш” ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “600000 тн/жил хүчин чадалтай сайжруулсан шахмал түлшний үйлдвэр” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

8 дугаар сарын сүүлч, 9 дүгээр сарын эхээр ажиглагдан 10 дугаар сарын сүүл, 11 дүгээр сарын эхээр өвлийн нөхцөлдөө шилжин ордог.

Тус нутаг дэвсгэрийн Хамгийн хүйтэн сар нь 1 дүгээр сар бөгөөд энэ үед Азийн эсрэг-циклоны хөгжил дээд цэгтээ хүрнэ. Түүний сарын дундаж температур Тэрэлж, Сэргэлэн сумын орчимд -21.6°C , Налайх орчимд -25.2°C байгаа бол хамгийн дулаан 7 дугаар сард Тэрэлжийн орчимд 13.0°C , харин Зуунмодод 18.7°C байна.

2.3 Хөрсөн бүрхэвч

Сайжруулсан шахмал түлшний үйлдвэр нь хөрс газарзүйн хувьд Хэнтийн нурууны баруун хэсгийн салбар уулсын уулын хар хүрэн ба тал газрын хар хүрэн хөрсний тойрогт хамрагдана. Төслийн талбай нь тал газар, хөндий хотгорын хөрсний хэв шинжтэй, ердийн хар хүрэн хөрс тархсан байна. Үйлдвэрийн хөрсөн бүрхэвчийн өнөөгийн төлөв байдлын хувьд 40-50 % нь антропогены хүчин зүйлийн нөлөөгөөр эвдрэлд өртсөн байна.




Зураг №. 4 Төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн хэв шинж



2.4 Ургамлан нөмрөг

Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Хэнтийн уулархаг тайгын урд, Монгол дагуурын ойт хээрт оршдог. Ургамалжилтын төрх байдлаар Хэнтийн нурууны салбар уулстай төстэй. Төслийн талбай нь тэгш талын хээр ба хуурай хээрийн хэв шинжтэй, хялгана, хиаг, алаг өвст бүлгэмдэл зонхилсон байна. Шахмал түлшний үйлдвэрийн ургамлан нөмрөгийн хувьд ургамлан нөмрөг нилэнхүйдээ талхлагдсан хог ургамал давамгайлсан байна.



Зураг №. 5 Төслийн талбайн ургамлан нөмрөгийн хэв шинж

2.5 Төсөл хэрэгжих орон нутгийн нийгэм эдийн засгийн байдал

Сэргэлэн сум: Төсөл хэрэгжиж буй Төв аймгийн Сэргэлэн сум нь 2021 оны байдлаар 2,084 хүн амтай, 760 өрхтэй байна.

Газар нутгийн хувьд Төв аймгийн Сэргэлэн сум нь газар нутаг нь 74 мян.км² талбайг хамардаг. Улаанбаатар хот болон Төв аймгийн Зуун мод, Алтанбулаг, Эрдэнэ, Баян, Баянцагаан сумтай хиллэдэг. Далайн түвшнээс дээш 1000-1500 м өргөгдсөн. Төв аймгийн Эрдэнэ, Баян, Баянцагаан, Зуун мод, Алтанбулаг гэсэн таван сум, Нийслэлийн




“Таван толгой түлш” ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “600000 тн/жил хүчин чадалтай сайжруулсан шахмал түлшний үйлдвэр” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хан-Уул, Баянзүрх, Налайх, Багахангай гэсэн дөрвөн дүүргээр хүрээлэгдэг. Сумын нутаг дэвсгэрийнх нь 16,4 хувийг ой мод, 36,5 хувийг хээрийн бүс эзэлдэг. Нутгийн хойд хэсгийн уулын өргөн хөндийнүүд нь газар тариаланд тохиромжтой хүрэн бор хөрстэй, өмнөд хэсэг нь гүвээ толгод бүхий тал хээр газар юм. Хэрлэн, Туул зэрэг том болон жижиг голуудтай.

Баянзүрх дүүргийн 11-р хороо: Тус хороо нь 3024 өрхийн нийт 9055 хүн амтайгаас 4520 нь эрэгтэй, 4535 нь эмэгтэйчүүд байна.

Газар нутгийн хувьд 35000 га нутаг дэвсгэртэй. Маршлын гүүрнээс Налайхын цагаан хаалга, Баянзүрх уул бүхлээрээ, Төв аймгийн Сэргэлэн сум, Дархан цаазат Богд хан уулын, Шаварт, Ширдэгт, Шажин хурах, Төр хурах, Бумат, Харгана, Бумбат, Чулуутын ам орно.



Зураг №. 6 Төсөл хэрэгжих сум, дүүргийн хил



БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1 Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэх гол агаар бохирдуулагч нь тоос тоосонцор байна. Ил задгай талбайд нүүрс ачиж буулгах, шигших, бутлах, туузан дамжуургаар тээвэрлэх үйл ажиллагаанаас тоос тоосонцор үүсдэг. Мөн нүүрс хадгалах талбай, нүүрсний хогоор бохирдсон зэргээс хуурай салхитай үед тоос дэгдэж салхины дагуу тархах ба нүүрсээр бүрхэгдсэн замаар зорчих тээврийн хэрэгслүүд нь тоосны дэгдэлтийг улам нэмэгдүүлж байна. Түүхий эд, бүтээгдэхүүнийг ачиж буулгах, зөөвөрлөхөд зарим хүнд даацын машин механизмуудыг ашиглах ба тэдгээрийн хаягдал утаа нь агаар бохирдуулах өөр нэг эх үүсвэр болно.

Шахмал түлшний үйлдвэрийн шат дамжлагууд нь нүүрсний тоосжилтыг бууруулах тоноглолгүйгээр ил задгай суурилагдсан, үйлдвэрийн байгууламжийн агааржуулалтын систем бүрэн бус зэргээс шалтгаалан хүрээлэн байгаа орчинд тоосны бохирдол үүсгэхээс гадна үйлдвэрийн дотоод орчны агаарт ихээхэн тоосжилттой байна. Түүхий эдийг бэлтгэх бүх шат дамжлагууд, бүх төрлийн тээвэрлэлтүүд, нүүрсний тоосоор бүрхэгдсэн задгай талбай нь тоосжилт үүсгэх эх үүсвэрүүд болно.

3.2 Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Хөрс бохирдуулагч эх үүсвэрүүдэд янз бүрийн дэд бүтцийн барилга байгууламжууд, техник тоног төхөөрөмжүүд, болон бусад сектороос ялгарч буй хорт нэгдлүүд, хог хаягдал, бохир ус зэрэг үүсвэрүүд байна.

- Антропогены хүчин зүйлээс үүдэн ажилчдын ариун цэврийн газар болон хоолны газраас гарах шингэн хаягдлын байгууламж байхгүй зэргээс үүдэн хөрс бохирдох
- Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаяагүй, мөн ангилан ялгаагүйгээс болж хөрсөнд удаан хугацаанд хадгалагдах
- Тоос хөрсөнд хуримтлагдаж бохирдол үүсэх
- Түүхий эд нь хөрсөнд нэвчсэнээс үүдэн хөрсөн орчинд нэвчин бохирдол үүсгэх

3.3 Ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Ачиж, буулгах хөдөлгөөнөөр орчны ургамлын бүрхэвч талхлагдах, ажиллагсад зориудын бус замаар явах, анхаарал болгоомжгүйгээс гал түймэр гарах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс олон салаа зам үүсэх, дэд бүтцийн барилга байгууламж барих



зэрэг нь ургамлын нөмрөгт нөлөөлөн, түүний төрөл зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах (хог ургамал ихсэх), зэрэг сөрөг нөлөөллүүд үүсч болзошгүй.

3.4 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Төсөл хэрэгжих явцад байгалийн усны нөөц болон усны бохирдолд үзүүлэх нөлөөлөл нь төдийлөн эрчимтэй бус юм. Гэвч ахуйн бохир ус болон хог хаягдлыг зөв байршуулаагүй мөн орчны цэвэрлэгээ хийгээгүйн улмаас газрын доорх ус, хөрсний ус бохирдуулж болзошгүй.

3.5 Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл үргэлжлэх хугацаа,эрчим

Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим: Уг төслийг хэрэгжүүлснээр байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, судалгаа хийсэн мэргэжлийн судлаачдын дүгнэлтүүдийг үндэслэн тогтоов. Байгаль орчны төлөв байдалд гарч болзошгүй нөлөөлөл, болзошгүй ослын үнэлгээг магадлан жагсаах аргаар тодорхойлов.

Магадлан жагсаах /checklist/ аргаар тооцсон нөлөөллийн үнэлгээ: Үнэлгээ хийгдэж буй төслийн үйл ажиллагаа байгаль орчны төлөв байдал, нийгэм эдийн засагт нөлөөлөх нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмийг тодруулахын тулд магадлан жагсаах (checklist) аргыг ашиглав. Энэ арга нь нөлөөллийг байна (х), байхгүй (хоосон) гэсэн хэлбэрээр тодорхойлж шууд, шууд бус шинжтэй, удаан, богино хугацаагаар буцалтгүй болон буцаж нөлөөлөх, хүчтэй, дунд болон бага зэрэг эрчимтэй байх зэрэг үзүүлэлтүүдээр авч үзсэн болно.

Төслийн байгаль орчинд сөргөөр нөлөөлөх эх үүсвэрүүдэд дараах хүчин зүйлс орж байна. Үүнд:

-  Авто тээврийн хэрэгслээс ялгарах хорт хий
-  Ачиж буулгах явцад үүсэх тоосжилт
-  Ачих, буулгах, тээвэрлэх үйл явц
-  Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт
-  Үйлдвэрийн болон тоног төхөөрөмжийн дуу чимээ

Төсөл хэрэгжсэнээр тухайн нутгийн байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй нөлөөллийг хүснэгт № 5-д харуулав.



“Таван толгой түлш” ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “600000 тн/жил хүчин чадалтай сайжруулсан шахмал түлшний үйлдвэр” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт №. 5 Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

№	Байгаль орчны үзүүлэлтүүд	Нөлөөлөх байдал			Хугацаа		Эргэлт		Эрчим		
		Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Бага	Дунд	Их
Байгалийн бүрэлдэхүүн хэсгийн өөрчлөлт											
1	Уур амьсгалын өөрчлөлт		x			x	x	x			
2	Усны чанар өөрчлөгдөх		x			x	x			x	
3	Гадаргын усны урсац өөрчлөгдөх	x				x		x		x	
4	Ургамлын экосистем өөрчлөгдөх	x				x	x				x
5	Хөрсөн бүрхэвч элэгдэх, эвдрэх	x				x	x			x	
6	Геологийн тогтоц өөрчлөгдөх		x		x			x	x		
7	Зэрлэг амьтдын тархац нутаг өөрчлөгдөх		x		x			x	x		
Байгалийн нөөц ашиглалт											
8	Бэлчээр, тэжээлийн байдал	x				x		x	x		
9	Эрдэс түүхий эдийн нөөц /ус/		x		x		x		x		
9	Эрчим хүчний нөөц		x		x		x		x		
Байгаль орчны өөрчлөлт											
10	Ундны усны чанар, хэмжээ		x		x		x		x		
11	Урсгал усны нөөцийн горим		x		x			x	x		
12	Агаарын бохирдол	x				x	x				x
13	Хөрсний бохирдол	x				x	x				x
14	Хорт бодис хүн, амьтанд нөлөөлөх		x			x	x		x		
15	Дуу чимээний нөлөөлөл	x				x	x			x	
Нийгэмд үзүүлэх нөлөөлөл											
16	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх		x		x		x		x		
17	Үйлчилгээний салбарын үйл		x		x		x		x		



“Таван толгой түлш” ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “600000 тн/жил хүчин чадалтай сайжруулсан шахмал түлшний үйлдвэр” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	ажиллагаанд нөлөөлөх										
18	Хүн амын орлого өөрчлөгдөх	х				х		х		х	
19	Хүн амын эрүүл мэнд, соёл		х		х		х		х		
Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор											
20	Байгалийн дүр төрх өөрчлөгдөх	х				х		х		х	
21	Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх		х			х		х		х	
22	Түүх соёлын дурсгалт зүйлс өөрчлөгдөх			х	х			х	х		
Нийгэм, эдийн засгийн асуудал											
23	Ядуурлыг бууруулахад дэмжих	х	в			х	х			х	
24	Ажлын байр нэмэгдэх	х				х	х			х	
25	Дүн	11	13	1	10	15	16	9	13	10	2

Тус үйлдвэрийн үйл ажиллагааг магадлан жагсаах аргаар байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмийг үнэлэхэд дараах үр дүн гарч байна.

Шууд нөлөөлөлд: Ургамлын экосистем өөрчлөгдөх, хөрсөн бүрхэвч элэгдэл эвдрэлд өртөх, бэлчээр, тэжээлийн байдал, агаарын бохирдол дуу чимээний нөлөөлөл, байгалийн дүр төрх, ландшафтын хэлбэр өөрчлөгдөх, хүн амын орлого өөрчлөгдөх зэрэг нийт 11 нөлөөлөл хамаарч байна.

Шууд бус нөлөөлөлд: Уур амьсгалын өөрчлөлт, усны чанар өөрчлөгдөх, геологийн тогтоц өөрчлөгдөх, зэрлэг амьтдын тархац нутаг өөрчлөгдөх зэрэг нийт 13 нөлөөлөл хамаарч байна.

Урт хугацааны нөлөөлөлд: Уур амьсгалын өөрчлөлт, усны чанар өөрчлөгдөх, хөрсөн бүрхэвч элэгдэх, ургамлын экосистем өөрчлөгдөх, агаарын бохирдол, дуу чимээний нөлөөлөл, байгалийн дүр төрх, ландшафтын хэлбэр өөрчлөгдөх, ажлын байр нэмэгдэх зэрэг нийт 15 нөлөөлөл хамаарч байна.

Буцаж нөлөөлөх нөлөөлөлд: Уур амьсгалын өөрчлөлт, усны чанар өөрчлөгдөх, хөрсөн бүрхэвч элэгдэх, ургамлын экосистем өөрчлөгдөх, агаарын бохирдол, хөрсний бохирдол, дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх зэрэг нийт 15 нөлөөлөл хамаарч байна.



“Таван толгой түлш” ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “600000 тн/жил хүчин чадалтай сайжруулсан шахмал түлшний үйлдвэр” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Буцалтгүй нөлөөлөлд: геологийн тогтоц өөрчлөгдөх, зэрлэг амьтдын тархац нутаг өөрчлөгдөх, хүн амын орлого нэмэгдэх дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх, ажлын байр нэмэгдэх зэрэг нийт 9 нөлөөлөл хамаарч байна.

Дунд нөлөөлөлд: гадаргын усны урсац өөрчлөгдөх, ундны усны чанар өөрчлөгдөх, хөрсөн бүрхэвч элэгдэл, эвдрэлд өртөх, ургамлын экосистем өөрчлөгдөх, дуу чимээний нөлөөлөл зэрэг нийт 10 нөлөөлөл хамаарч байна.

Бага нөлөөлөлд: Түүх соёлын дурсгалт зүйлс өөрчлөгдөх, эрчим хүч, эрдэс түүхий эдийн нөөц өөрчлөгдөх, зэрлэг амьтдын тархац нутаг өөрчлөгдөх, геологийн тогтоц өөрчлөгдөх зэрэг нийт 13 нөлөөлөл хамаарч байна.




График №. 1Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим



“Таван толгой түлш” ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “600000 тн/жил хүчин чадалтай сайжруулсан шахмал түлшний үйлдвэр” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

БҮЛЭГ 4. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг илрүүлэх, тэдгээрийн үр дагаврыг тогтмол хянах, хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд нутгийн иргэдийн оролцоог хангах, дэмжих зарчим баримтлан ажиллах үүрэгтэй. Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн бөгөөд үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш жил бүр байгаль орчны нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрийг арилгах бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хянан үзэж, шинэчлэн сайжруулж, байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дагавар, бодит байдалтай уялдуулан улам баяжуулж, сайжруулан мөрдлөг болгоно.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа төслийн үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөөг нөлөөлөлд өртөж болзошгүй байгалийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр авч үзэж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө зардлыг БОАЖЯ-ны Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулав.

Хүснэгт №. 6 БОМТ-ний зардал

2023 оны БОМТ-н нийт зардлын тооцоо		
№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	2023 оны зардал төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2 500 000
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	19 100 000
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1 500 000
5	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	800 000
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2 042 000
7	БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулах	11 000 000
8	БОМТ-н хэрэгжилтийг тайлагнах	1 000 000
	Нийт	37 942 000



“Таван толгой түлш” ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “600000 тн/жил хүчин чадалтай сайжруулсан шахмал түлшний үйлдвэр” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах менежментийн төлөвлөгөө

Хүснэгт №. 7 Сөрөг нөлөөллийг бууруулах менежментийн төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөлийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамаарах хүрээ	Нэгжийн зардал	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, эрх зүйн орчин
Агаарын орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах менежментийн төлөвлөгөө						
Ил задгай талбайд нүүрс ачиж буулгах, шигших, бутлах, туузан дамжуургаар тээвэрлэх үйл ажиллагаанаас тоос тоосонцор үүсэх. Мөн нүүрс хадгалах талбай, нүүрсний хогоор бохирдсон зэргээс хуурай салхитай үед тоос дэгдэж салхины дагуу тархах ба нүүрсээр бүрхэгдсэн замаар зорих тээврийн хэрэгслүүд нь тоосны дэгдэлтийг улам нэмэгдүүлэх. Түүхий эд, бүтээгдэхүүнийг ачиж буулгах, зөөвөрлөхөд зарим хүнд даацын машин механизмуудыг ашиглах ба тэдгээрийн хаягдал утаа	Агаарын чанарын шинжилгээг тогтмол хийлгэх	Үйлдвэр орчим	-	ОХИХ-т тусгагдсан	2023 он	MNS 4585:2016” “Гадаад орчны агаарын түгээмэл бохирдуулагчийн хүлцэх агууламж болон зөвшөөрөгдөх түвшин MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 5002:2000 /Гадаад орчны шуугианы зөвшөөрөгдөх түвшин/ Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага стандартууд Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
	Дулааны улиралд үйлдвэрийн зам талбай усалж чийгшүүлж байх	Үйлдвэрийн зам талбай	-	Ү.а-ны зардлаар	2023 он	
	Автомашин хурдыг боломжит хэмжээгээр хязгаарлах	Үйлдвэрийн зам	-	Ү.а-ны зардлаар	2023 он	
	Тоос бууруулах орчин шинэ дэвшилтэт технологи судлах	Үйлдвэр орчим	-	Ү.а-ны зардлаар	2023 он	
	Тоосжилт бууруулах зорилгоор салхи шуурганд тэсвэртэй салхины хашаа барих	Үйлдвэр орчим	-	Ү.а-ны зардлаар	2023 он	
	Үйлдвэрийн орох гарах хэсгийн зам талбайд хайрга дэвсэх	Үйлдвэр орчим	-	1 000 000	2023 он	
Хөрсөн орчин болон ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах менежментийн төлөвлөгөө						
Үйл ажиллагааны явцад хөрсний бүтэц найрлагад өөрчлөлт	Үйлдвэрийн оффис орчмын халцарч бохирдсон талбайд	Оффис орчмын талбай		Орчны тохижилт нөхөн сэргээлтийн	2023 он	“Газрын тухай” хууль



“Таван толгой түлш” ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “600000 тн/жил хүчин чадалтай сайжруулсан шахмал түлшний үйлдвэр” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

орох, хог хаягдал, тоосжилтоос бохирдол үүсгэх, хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх. Шатах тослох материал, барилгын материалын хог хаягдал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	ногоон байгууламж хийх			төлөвлөгөөнд тусгагдсан.		MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага MNS
	Автомашины ажилласан тос масло түр хадгалах цэг байгуулах, хөрсөнд алдагдахаас сэргийлэн цементлэх	Үйлдвэр орчим		Хог хаягдлын төлөвлөгөөнд тусгагдсан.	2023 он	
	Хөрсний шинжилгээг тогтмол хийлгэх	Үйлдвэр орчим		ОХШХ-т тусгагдсан	2023 он	
	Үйлдвэрийн орчны замыг стандартын дагуу тэмдэгжүүлэх ажил хийх	Үйлдвэр орчим		1 000 000	2023 он	
Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах менежментийн төлөвлөгөө						
Усны нөөц ашиглалт, усны бохирдол үүсэх	Хаягдал ус хаях, зайлуулах гэрээт компани ажилд хяналт тавих	Үйлдвэрийн хаягдал ус	-	-	2023 он	Усны тухай хууль болон бусад дүрэм, журам, стандартууд
	Ус ашиглах дүгнэлт авах	Үйлдвэрийн худаг	-	Ү.а-ны зардлаар	2023 он	
	Ус авах цэгт тоолуур байрлуулж,баталгаажуулах	Үйлдвэрийн худаг	-	Ү.а-ны зардлаар	2023 он	
	Ус ашигласны төлбөр төлсөн баримт архивлах		-	-	2023 он	
	Цэвэр ус болон хаягдал усны хяналт шинжилгээг тогтмол хийх	Үйлдвэр орчим		500 000	2023 он	
Нийт			2 500 000			



“Таван толгой түлш” ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “600000 тн/жил хүчин чадалтай сайжруулсан шахмал түлшний үйлдвэр” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

4.2 Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд ЭТТ ХК -аас “Сая тонн-Сая мод” хөтөлбөр хэрэгжүүлж Таван толгой түлш ХХК-д үүрэг өгсний дагуу төсөл хэрэгжих талбайд хавар болон намрын улиралд бүх нийтийн мод тарих өдөрлөг зохион байгуулна.

Хүснэгт №. 8 Орчны тохижилт нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Орчны тохижилт нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Төслийн талбайд элэгдэл, эвдрэлд өртсөн газрыг тохижуулах	Биологийн нөхөн сэргээлт	Үйлдвэрийн талбайд ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэн зүлэгжүүлэх	кг	50	32 000	1 600 000	2023 он	Газрын тухай хууль MNS 5973:2009
Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих		Шилмүүст мод	ш	3000	5 000	15 000 000	2023 он	
		Навчит мод	ш	500	5 000	2 500 000	2023 он	
Нийт						19 100 000	2023 он	

4.3 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Тус төслийн талбайд одоогоор түүх, соёлын өв илрээгүй. Тус төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах шаардлагатай.



“Таван толгой түлш” ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “600000 тн/жил хүчин чадалтай сайжруулсан шахмал түлшний үйлдвэр” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

4.4 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт №. 9 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Цаг агаарын гэнэтийн үзэгдлээс үйлдвэрийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Цаг агаарын улирлын, сарын, долоо хоногийн, өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд тогтмол ашиглах	Цаг агаарын мэдээ ашиглаж байх.	Ү.а-ны зардлаар		2023 он	Гамшгаас хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль ISO/PAS 45005:2020 “Ковид-19 цар тахлын үед аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгаа
Ажилчдын хариуцлагагүй байдлаас шалтгаалан осол гарах	Үйлдвэрлэлийн ажлын байрны ажилбар бүрд эрсдэлийн үнэлгээ хийх, холбогдох арга хэмжээ авах	Эрсдэлийн үнэлгээг тогтмол хуваарийн хийх.	Ү.а-ны зардлаар		2023 он	
	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг сурталчлах, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр компани гаргасан дүрэм, журам, зааврыг шинэчлэн боловсруулах, мөрдүүлэх	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны гарын авлагатай болох.	Ү.а-ны зардлаар		2023 он	
	Болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэл холбооны хэрэгсэлтэй болох	Ус, элс, шороо, хүрз цэвэрлэгээний бодис, холбооны хэрэгсэл гэх мэт	400 000	400 000	2023 он	
	Аюул ослоос урьдчилан сэргийлэх зааварчилгаа, дохио, санамж, анхааруулах тэмдэг тэмдэглэгээ хаалт хамгаалалтыг ажлын байранд байршуулах	Анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байршуулах.	400 000		2023 он	
	Нийт ажилтны ХАБЭА-н сургалт зохион байгуулах	ХАБЭА-ийн сургалтыг тогтсон хуваарийн дагуу зохион байгуулах	Ү.а-ны зардлаар		2023 он	



“Таван толгой түлш” ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “600000 тн/жил хүчин чадалтай сайжруулсан шахмал түлшний үйлдвэр” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх, байгалийн гамшиг	Үйлдвэрийн бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрийн барилга, миддлингийн овоолго, зөөврийн сууц, хүнд механизм, тээврийн хэрэгслийн галын аюулгүй байдлын үзлэг, шалгалтыг тогтмол явуулах	Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх	Ү.а-ны зардлаар	2023 он	
	Үйлдвэрийн бүсэд гарсан гал түймрийг унтраах ажиллагааг шуурхай зохион байгуулах	Гал унтраах ажиллагааг тогтмол зохион байгуулах..			
	Гал түймрийн дуудлагыг тухай бүр сар, улирал, жилээр бүртгэж тайланд хавсаргах	Цаасан болон файл хэлбэрээр тайлан мэдээ гаргах.			
	Үйлдвэрийн хэмжээнд гал унтраагуур, галын усан шугам, авралтын зам гарцын бэлэн байдлыг шалгах, зөрчил илэрвэл арилгуулах	Зөрчлийг холбогдох арга хэмжээгээр арилгах.			
	Компанийн алба, хэлтсүүдтэй хамтран болзошгүй гамшиг, гал түймрийн үед гал унтраах дадлага сургуулилтыг зохион байгуулах	Дадлага сургуулилтыг зохион байгуулах.			
Эрүүл мэнд	Мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийн судалгаа хийх, үйлдвэрийн ажилтныг эрүүл мэндийн карттай болгох түүний мөрөөр урьдчилсан сэргийлэх арга хэмжээ авах	МШӨ-ийн судалгаа бүрэн гаргасан байх.			
	Яаралтай тусламжийн өрөөг эмнэлгийн тоног төхөөрөмжөөр тохижуулах. Эм тариа болон ороох боох материалын нөөцтэй байлгах.	Тоног төхөөрөмж, эм тариа бараа материалыг худалдан авсан байх /боолт, шархны наалт, халдваргүйжүүлэх уусмал гэх мэт/			
	Ажилчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах	Нийт ажилчдыг урьдчилсан сэргийлсэн үзлэгт хамруулсан байх			



“Таван толгой түлш” ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “600000 тн/жил хүчин чадалтай сайжруулсан шахмал түлшний үйлдвэр” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	COVID-19 цар тахлын үед төлөвлөгөө график гарган бүртгэл судалгаатай ажиллах.	Ковид-19 цар тахлын төлөвлөгөө гаргасан байх.			
Нийт зардал (мян.төг)			800 000		

4.5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт №. 10 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Төсөл хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт, стандарт
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй	Энгийн хог хаягдлыг ангилан ялгадаг, шаардлага хангасан зориулалтын хогийн савтай болох, аль болох олон газарт байрлуулах	Үйл ажиллагааны турш	-	-		500.0	2023	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл
	Ахуйн хог хаягдлаа цуглуулах, тээвэрлэх эрх бүхий байгууллага болон тогтоосон цэгт хүлээлгэн өгөх	Үйл ажиллагааны турш	-	-	-	Ү.а-ны зардлаар	2023	
	Хог хаягдлыг ангилан цуглуулах цэгийг хашаажуулах, тэмдэг тэмдэглэгээ тавих	Үйл ажиллагааны турш	-	-	-	200.0	2023	
	Автомашин ажилласан тос масло түр хадгалах цэг байгуулах, хөрсөнд алдагдахаас сэргийлэн цементлэх	Үйл ажиллагааны турш	-	-		800.0	2023	
Нийт		1 500 000 төг						



“Таван толгой түлш” ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “600000 тн/жил хүчин чадалтай сайжруулсан шахмал түлшний үйлдвэр” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

4.6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт №. 11 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал мян.төг	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Хөрсний бохирдол							
Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент,хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх Түлш, тосолгооны материал болон хог хаягдлаар хөрс бохирдох	Төслийн талбайд 5 цэгт 5 дээж /үйлдвэр орчмын талбай болон оффис хэсэгт/	2023 он	Жилд 2 удаа	20 000	5 дээж х жилд 2 удаа х 20,0 НИЙТ: 200 000	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга,
Хүнд металлын агууламж		5 цэгт 5 дээж /үйлдвэрийн талбайн болон оффис орчим /	2023 он	Жилд 2 удаа	25 000	5 дээж х жилд 2 удаа х 25,0 Нийт: 250 000	MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага
Усны хяналт шинжилгээ							
Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Төслийн талбай орчим	Унд ахуйн уснаас	2023 он	Жилд 2 удаа	46 000	1 дээж х 46.0 х жил 2 удаа НИЙТ: 92 000	MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 13.060.50 Усны чанарын стандарт



“Таван толгой түлш” ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “600000 тн/жил хүчин чадалтай сайжруулсан шахмал түлшний үйлдвэр” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

							MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
Агаарын чанар, дуу чимээ							
Тоосжилт (PM ₁₀ , PSM, PM ₂₅); Гадаад болон дотоод орчны дуу чимээ, доргио, чичиргээ; Ажлын байрны эрүүл ахуйн үзүүлэлтүүд (тоос, дуу чимээ, гэрэлтүүлэг, чийгшил болон физик бохирдлын түвшин); Бохирдлын цэгэн эх үүсвэр (O ₂ , SO ₂ , NO ₂ , CO)	Төслийн талбай болон орчны бүсэд	Жилд 2 удаа	2023 он	Жилд 2 удаа	150 000	5 цэг х 150 х жилд 2 удаа НИЙТ: 1 500 000	MNS5885:2008 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5002:2000
Нийт						2 042 000	

4.7 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт №. 12 Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг сая.төг	Зардал сая.төг	Хугацаа
1	Хөдөлмөр хамгаалал эрүүл ахуйн нөхөцлийг сайжруулах сургалт зохион байгуулах, байгаль орчныг хамгаалах, осол аваар, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалт зохион байгуулах	Төслийн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		2023 он



“Таван толгой түлш” ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “600000 тн/жил хүчин чадалтай сайжруулсан шахмал түлшний үйлдвэр” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ-т хүргэн өгч байх	Төслийн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		Жил бүрийн 11 сард
3	Бүх ажилчдыг жилд 1 удаа эмчийн үзлэгт хамруулж байх	Төслийн хэмжээнд	Дотоод төлөвлөлтөөр		2023 он
4	ХАБЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогтмолжуулж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах ажлыг зохион байгуулах	Төслийн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		2023 он
5	Ажилчдыг шаардлагатай хувцас, тусгай хамгаалах, амны хаалт, каск зэргээр хангах	Төслийн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		2023 он
6	Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлд зарцуулах зардал	Төслийн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		2023 он
7	Ковидын нөхцөлд ажилчдын дархлааг дэмжих бүтээгдэхүүнээр хангах	Төслийн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		Жилд 2 удаа
8	Байгаль орчны хамгаалах тухай хуулийн 10 ¹ дүгээр зүйлд заасны дагуу Байгаль орчны аудитыг хийлгэх	Төслийн хэмжээнд	10 000 000	10 000 000	2023 он
9	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны тайланг хийлгэх	Төслийн хэмжээнд	1 000 000	1 000 000	2023 он
10	Авто тээврийн хэрэгслийг жил бүр үзлэгт хамруулж, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг цаг тухайд нь хийх	Төслийн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		2023 он
Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал				11 000 000	

4.8 Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Хүснэгт №. 13 Оршин суугчидад тайлагнах төлөвлөгөө

БОМТ түүний хэрэгжилтийг тайлагнах, оролцогч талууд	Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэрүүд	Мэдээний агуулаг	Хугацааны тов	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
---	---------------------------------	------------------	---------------	---	------------------------



“Таван толгой түлш” ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “600000 тн/жил хүчин чадалтай сайжруулсан шахмал түлшний үйлдвэр” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Багийн иргэдтэй уулзах	БОМТ хэрэгжилтийн тайланг хүргүүлэх, тайлагнах	БОМТ-ийн тухайн жилийн тайлан, ирэх оны төлөвлөгөө	11 сард	БО-ны мэргэжилтнүүд	Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р баг
Төв аймгийн байгаль орчны газар	БОМТ хэрэгжилтийн тайланг хүргүүлэх, тайлагнах		11 сард		Төв аймаг
Нийслэлийн байгаль орчны газар	БОМТ хэрэгжилтийн тайланг хүргүүлэх, тайлагнах		11 сард		Улаанбаатар хот
БОАЖЯ	Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр болон файл хэлбэрээр хүргүүлэх		12 сард		